



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 13 өдөр

Дугаар А/249

Булган сум

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны XIV Хуралдааны “Булган аймгийн 2023 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай” XIV/01 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын “Шинэ хөгжлийн зам” үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай 2020 оны III/04 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2023 оны А/112 дугаар “Хөтөлбөр, төлөвлөгөө, арга хэмжээний зардлыг санхүүжүүлэх тухай” захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нэгдсэн эмнэлгийн Дотрын тасгийн сувилахуйн тусламж үйлчилгээг сайжруулахад шаардлагатай 500,000 (таван зуун мянга) төгрөгийн дэмжлэгийг үзүүлсүгэй.

2. Дэмжлэг тусламжийг “Эрүүл мэнд” хөтөлбөр арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газар (Д.Алтаншагай)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ